



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

№82 /526/

2023.05.22

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ХӨДӨЛГӨӨНТ АМБУЛАТОРИ АРХАНГАЙ АЙМАГТ 3 САРЫН ХУГАЦААНД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичиг, БХЯ-ны 2023 оны төлөвлөгөөний дагуу Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулаторийн 3 ээлжийн 62 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, техникч, жолооч нар Архангай аймгийн 13 суманд "Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг"-ийг 80 гаруй хоногийн хугацаанд зохион байгууллаа.

Үзлэгт нийт 5898 иргэн хамрагдсан бөгөөд сум орон нутгийн газар зүйн онцлогоос хамаараад өвчлөлийн бүтэц харилцан адилгүй

байна. Тухайлбал, уулархаг бүсэд орших хойд болон баруун сумдын (Жаргалант, Өндөр-Улаан, Тариат) иргэдийн дунд бамбайн булчирхайн эмгэгийн тохиолдол зонхилж буй нь ундны усны йодын хэмжээ бага байдагтай холбоотой аж. Мөн нийт сумдаар ходоодны архаг үрэвсэл, ходоод улаан хоолойн сөөргөө өвчин, мэдрэлийн эрхтэн тогтолцоо, чих хамар хоолойн эмгэг, шүдний өвчлөл элбэг байгаагийн зэрэгцээ үзлэгт хамрагдсан нийт иргэдийн 736 хүнд элэгний С вирус, 321 хүнд В вирус халдвар байгаа нь шинжилгээгээр илэрсэн

бөгөөд элэгний вирус халдварын тархалт, түүнээс шалтгаалсан элэгний хавдрын өвчлөл цаашид өсөх хандлагатай байгааг эмч нар дурдаж байна.

Мөн үзлэгийн явцад хавдрын болон хавдрын урьдал эмгэгийн 93 тохиолдол бүртгэгдсэний 4 нь элэгний хавдрын, 59 нь умайн хоргүй хавдрын, 16 нь өндгөвчний хавдрын, 14 нь ходоод улаан хоолойн хавдрын урьдал эмгэгийн тохиолдол байжээ.

Үзлэг хийгдсэн 13 сумын дүнгээр Архангай аймагт зохиож байгаа өвчлөлийг авч үзвэл зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг (артерийн даралт ихсэх өвчин), хоол боловсруулах тогтолцооны эмгэг (ходоодны архаг үрэвсэл, ходоод улаан хоолойн сөөргөө, шүдний эмгэг), элэгний В болон С вирус халдварын тохиолдол, дотоод шүүрлийн тогтолцооны эмгэг (бамбайн булчирхайн зангилаа болон уйланхайт өөрчлөлт), мэдрэлийн тогтолцооны эмгэг (бүсэлхий нурууны ёзоорын эмгэг, толгойн өвдөлт) гэсэн 5 төрлийн эрхтэн тогтолцооны эмгэг болон өвчлөл өндөр байгаа аж.

Түүнчлэн Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулатори нь үзлэгийн явцад зүрхний баруун ховдлын эрт үеийн шигдээстэй өвчтөнийг цаг тухайд нь оношлон яаралтай тусламж үзүүлж, дараагийн шатлалын эмнэлэгт илгээсэн, ахуйн гэмтлийн шалтгаант нүүрний шарханд хугацаа алдахгүй газар дээр нь тусламж үйлчилгээ үзүүлсэн, 9 сартай, хяналтгүй, тулгамдсан, анхан төрөгчид эх барихын тусламж үйлчилгээг үзүүлж эсэн мэнд амаржуулсан зэрэг нэн яаралтай тусламж үйлчилгээнүүдийг үзүүлжээ.

Ийнхүү Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт амбулаторийн эмч мэргэжилтнүүд нийслэлээс алслагдсан сум орон нутгийн малчид, хөдөлмөрчдөд газар дээр нь хүрч үйлчлэн "Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг"-ийг шат дараалан явуулж буй нь хөдөөгийн иргэдийн талархлыг хүлээсэн, үр дүнтэй ажил болж байгаа юм.

## "БИДНИЙ БАХАРХАЛ" ТӨСӨЛ ОРХОН СУМАНД...



Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчилж, "Бидний бахархал" төслийг Булган аймагт хэрэгжүүлэх арга хэмжээ Орхон суманд үргэлжилж байна. Энэ үеэр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай батлан хамгаалах бодлого зорилт, үйл ажиллагааны талаар нутгийн иргэдэд мэдээлэл өгсөн юм. Мөн Ардын багш доктор, профессор, хурандаа Г.Мягмаржав "Монгол эр хүн" сэдвээр лекц уншлаа. Тэрээр эр хүн бол хуулиар олгогдсон үүргийнхээ дагуу эх орноо батлан хамгаалахаас гадна өрх гэрийн тэргүүн, ноён нуруу нь байж сахилга бат, ухамсар төлөвшилийг хэзээд эрхэмлэх нь зөв зүйтэй гэдгийг онцолсон юм.

Түүнчлэн Байлдааны гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хүндэтгэлийн тоглолтоо толилууллаа. Түүнчлэн "Бидний бахархал" төслийн хүрээнд нутгийн ард иргэдэд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн офицер, ахлагч нарын гардан тулааны болон хугацаат цэргийн алба хаагчдын жагсаалын үзүүлэх тоглолт, ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн политехникийн коллежийн үзүүлэх тоглолтыг сонирхууллаа. Мөн БХТА, Монгол цэргийн музей, "Алдар" спорт хорооны танилцуулга үзэсгэлэнг дэлгэж, иргэдэд

хэрэгцээ шаардлагатай мэдээ мэдээлэл, лавлагаа үйлчилгээг хүргэн ажиллав. Мөн Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн цэргийн алба хаагчид одоо ашиглагдаж буй зэвсэг, шүхэр, шүхрийн дагалдах хэрэгслийн үзэсгэлэнг дэлгэж иргэдэд сонирхуулсан юм.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар хэрэгжиж байгаа "Бидний бахархал" төслийн арга хэмжээнд хамрагдсан Булган аймгийн Орхон сумын хүүхэд залуучууд, иргэд хөдөлмөрчдийн дунд 3x3 сагсан бөмбөгийн болон шатрын тэмцээнийг зохион байгуулсан юм. "Бидний бахархал" төсөл нь энэ сарын 25-ны өдрийг хүртэл Булган аймгийн бүх сумдаар хэрэгжих юм.

Дэслэгч Б.ЭРДЭНЭБАТ



## "БИДНИЙ БАХАРХАЛ" ТӨСЛИЙН АРГА ХЭМЖЭЭ БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ СУМАНД ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Батлан хамгаалахын хууль тогтоомжийг сурталчилж, "Бидний бахархал" төслийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээ Булган аймгийн сумдад үргэлжилж байна. Энэ хүрээнд тус аймгийн Тэшиг сумын иргэд, ЕБС-ийн сурагчид, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдад танилцуулга мэдээллийг хүргэж, тодорхой сэдвүүдээр лекц уншлаа. Тодруулбал, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга хурандаа Р.Энболд Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн бол ҮБХИС-ийн ахмад багш бэлтгэл хурандаа С.Энхтайван "Залуучуудын эх оронч үзэл хүмүүжлийн онцлог асуудлууд" сэдвээр лекц уншсан юм.

Мөн тус сумын ЕБС-ийн сурагчдын дунд сагсан бөмбөгийн 3x3 тэмцээнийг зохион байгуулж түрүүлсэн багийн тамирчид болох ЕБС-ийн 11а ангийн сурагч Ц.Гантогтох, Э.Мөнхтүшиг, Т.Өсөх-Ирээдүй нарт БХЯ-ны "Шонхор" хүүхдийн зусланд

амрах эрхийн бичиг гардуулав. Түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчин цэргийн алба хаагчдаа энхийг дэмжих ажиллагаанд оролцуулж эхэлсний 20 жилийн ойд зориулан бэлтгэсэн "Энхийн үйлсэд 20 жил", эх орон, эх түүхээрээ бахархах үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн "Тусгаар тогтнолын үнэ цэн" баримтат киног хүрэлцэн ирсэн иргэд, хүүхэд залуучуудын хүртээл болголоо. Арга хэмжээний төгсгөлд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хэсэгчилсэн урлагийн тоглолтыг толилуулсан юм. Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хөгжмийн салааны алба хаагчид дуут жагсаалын үзүүлбэр, хугацаат цэргийн алба хаагчид жагсаалын, Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн цэргийн алба хаагчид гардан тулааны үзүүлэх тоглолтыг сумын нийт иргэд, хүүхэд залууст сонирхуулав.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 3


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 29

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,460	3,466
EUR 🇪🇺	3,770	3,789
CNY 🇨🇳	501	503
RUB 🇷🇺	42.50	43.40
JPY 🇯🇵	25,50	26,10
KRW 🇰🇷	2.58	2.63

### ЗУРХАЙ



2023.05.22 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 3

**ЗУНЫ ТЭРГҮҮН УААГЧИН МОГОЙ САР**  
**ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Эд мал баялаг төгөлдөр болно**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**05.06-20.32**  
**Барилдлага:**  
**Рашаан**  
**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**  
**Сэрэхүй**

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 688,379,964
Эдгэрсэн	Нийт: 660,813,344
Нас барсан	Нийт: 6,874,902

Цахим шууданд

# БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ч.ЦОГТЖАРГАЛ ЭНЭТХЭГ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН ХҮЧНИЙ ХУРАЛД...



Ч.Цогтжаргалыг хүлээн авч уулзаж, хоёр орны Зэвсэгт хүчин тэр дундаа Хуурай замын цэргийн хамтын ажиллагааны талаар санал солилцов. Энэ үеэр Монгол Улсын Зэвсэгт хүчин АНУ-ын Энэтхэг-Номхон далайн цэргийн командлалын хамтарсан "Хааны эрэлд" олон улсын сургууль болон "Зэв" хамтарсан сургуулийн ач холбогдлын талаар Монголын талаас онцлон дурдсан.

Мөн бригадын генерал Ч.Цогтжаргал Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Хуурай замын цэргийн командлагч генерал Ясунори Моришита болон Бангладеш Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч генерал Шафиудин нартай хоёр талын уулзалт хийлээ.

Генерал Ясунори Моришита Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй илүү өргөн хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлж, "Зам" сургалт, дадлагаар Монголын цэргийн инженерүүд чадваржиж байгаа гэдэгт итгэлтэй байна гэсэн юм.

**ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ**

Монгол Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал АНУ-ын Энэтхэг-Номхон далайн Хуурай замын цэргийн командлагч генерал Чарлес Флинний урилгаар Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн Хуурай замын цэргийн хүчний хуралд оролцоод ирлээ.

АНУ-ын Хуурай замын цэргийн холбооноос АНУ-ын Хавай мужид 10 дахь удаагаа зохион байгуулагдсан уулзалт, үзэсгэлэн нь энэ жил "Орчин үеийн байлдааны ажиллагаанд гарч буй өөрчлөлтүүд" үндсэн сэдвийн хүрээнд илтгэл, хэлэлцүүлэг хэлбэрээр явагдсан бөгөөд Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн 30 орчим орны Хуурай замын цэргийн төлөөлөгч, түүний дотор 14 орны Хуурай замын цэргийн командлагч биечлэн оролцсон юм.

Орон орны Хуурай замын цэргийн

төлөөлөгч нар үндсэн илтгэлээс гадна "Техник технологи болон дайны шинээр гарч буй өөрчлөлтүүд", "Пуужин, холын тусгалын галын хэрэгслүүд болон тагнуулын технологийн хөгжил", "Газрын дайны шинэ эрин", "Цэргийн бэлэн байдлыг хангах орчин үеийн сорилтууд", "Сингапурын арми ба дайны өөрчлөлт", "Энэтхэг-Номхон далай дахь олон талт сургалт, дадлагын өнөөгийн байдал", "Шинээр гарч болох үзэл баримтлал" гэсэн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, АНУ-ын Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын танилцуулга болон орчин үеийн цэргийн зэвсэглэл, техник технологи, бараа бүтээгдэхүүнийг үзэж сонирхсон юм.

Тус уулзалт, үзэсгэлэнгийн явцад АНУ-ын Энэтхэг-Номхон далайн Хуурай замын цэргийн командлагч генерал Чарлес Флинн бригадын генерал

# КОМАНДАЛЫНХАН ОРЧНЫ НОГООН БАЙГУУЛАМЖАА НЭМЭГДҮҮЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон Зэвсэгт хүчинд нэгтгэл, ангиудад хэрэгжиж байгаа "Хүний хөгжлийн эко, ногоон орчныг бүрдүүлбэ" төслийн хүрээнд Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн байнгын байрлалын гадна, дотно орчинд гацуур, шинэс модны суулгацыг тарьж суулгалаа.

Модны суулгац тарихын өмнө агрономич З.Болдбаатар бүрэлдэхүүнд хэрхэн тарих, хэрхэн арчлах, юунд анхаарах тухай мэдээлэл хүргэв. Тэрээр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын мод тариалалтад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, заавар зөвлөгөө өгч байгаа агрономич юм. З.Болдбаатар ярихдаа "Та бидний ухсан модны тогоо буюу нүх нь том байх тусмаа сайн. Том байж, үндэсний систем нь тэлж, мод өндөр, сүрлэг ургана. Мэдээж нүх нь модны онцлогоос хамаарах бөгөөд ойролцоогоор 50-60 см гүн заавал ухсан байх ёстой. Моддоо суулгахын өмнө хөрсөө бас бэлдэх

хэрэгтэй. Бордоо, хар шороо, элсийг багсарч холиод үндсээ далд ортол нь чигжиж булна. Зарим хүн нүхнийхээ шороог эргүүлж булдаг, энэ бол буруу. Хатуулаг ихтэй учраас ургах магадлал буурна гэсэн үг. Усалгааны хувьд өглөө, оройдоо хөрс рүүгээ чиглүүлж усална. Мөчир рүү усаар шүршихээр амархан гэмтэж, хугардаг" зэрэг мэдээллийг хүргээд, арчилгаа, тордолгоог нь сайн гүйцэтгэж чадвал гацуур жилдээ 40-50 см ургадаг гэсэн юм.

Хуурай замын цэргийн командлалынхан байнгын байрлал болон албан тушаалын 30 айлын орон сууцны эргэн тойрны ногоон байгууламжийг нэмэгдүүлэхийн сацуу түүнийг дагасан тохижилтын ажлуудыг гүйцэтгэж байна.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийхэн 2030 он гэхэд 27 сая ширхэг мод тарьж, 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд үүний нэг нь алба хаагчдынхаа ажиллах ая тухтай орчныг бүрдүүлж, ногоон хотхон байгуулах зорилт билээ.

# "ЗАЛУУ ҮЕ-ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛАА



БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, ЗХУ-ын Маршал Г.К. Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар анги Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулга уулзалтыг угтан хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын ирээдүй болсон залуу үеийн төлөөлөл, Дорнод аймгийн хэрлэн сумын Улсын тэргүүний 11 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдад Монгол Улсын Зэвсэгт Хүчин, анги, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, эх оронч сэтгэлгээг бадраах, төлөвшүүлэх зорилгоор "Залуу үе-Эх орны ирээдүй" сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг ерөнхий боловсролын сургуулийн орчинд явууллаа.

Энэхүү арга хэмжээний хүрээнд ахлах ангийн сурагчдыг ангийн байрлалд хүлээн авч урлагийн хэсэгчилсэн тоглолт, гардан жагсаалын үзүүлэх тоглолт, буудлагын зэвсэглэлийн үзэсгэлэнг сонирхууллаа.

# ЦЭРЭГ, ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ БАГА НАСНААС НЬ



Зэвсэгт хүчний 303 харилцааг бэхжүүлэх ажлын дугаар анги нь иргэн цэргийн хүрээнд Хан-Уул дүүргийн 21

дүгээр хороонд байрлах "Соньхон ертөнц" цэцэрлэгийн багш ажилчид болон дунд бүлгийн хүүхэд багачуудад ангийн өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулах нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд хүүхэд багачуудад ангийн бие бүрэлдэхүүний ажил үүргийн онцлог, онгоц нисдэг тэрэгний засварын төвийн үйл ажиллагааг танилцуулсны зэрэгцээ онгоц, нисдэг бодитоор үзэж сонирхох боломжийг олгосон юм.

Эл өдөрлөг нь бяцхан үрс, хүүхэд багачуудад эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдний танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болж өндөрлөлөө.

**Ахмад Г.БИЛГҮҮТЭЙ**

# ТАСАГ, АЛБА, САЛБАР СУРТАЛЧЛАХ АЯНЫГ ӨРНҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 5 км-ын явган аялал, флаш моб бүжгийн тэмцээн зэрэг ажлуудыг зохион байгуулав.

Өдөрлөгийн төгсгөлд мотобуудлагын рот, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчлан ангийн нээлттэй хаалганы шалгаруулах волейбол, сагсан бөмбөг, туухай өргөлт, теннис, биллиард, хөл бөмбөг, Баянхонгор аймгийн

Ерөнхий боловсролын 4 зэмсгийг дэлгэн сургуулийн ахлах, дунд үзүүлсний зэрэгцээ бие бага ангийн 300 гаруй бүрэлдэхүүн урлагийн сурагчид оролцлоо. Тус номер, жагсаалын өдөрлөгийн үеэр зэвсэг, болон гардан тулааны техник, химийн багаж үзүүлэх тоглолтыг хийж хэрэгсэл, хөгжмийн гүйцэтгэлээ.

